



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



ᠨᠣᠷᠢᠨ ᠰᠢᠨᠬᠡ  
ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ  
ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ  
ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ ᠰᠢᠨᠬᠡᠭᠢᠨ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

2023 ОН

# АГУУЛГА

---

НЭГ.	ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	6–7
ХОЁР.	ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	8–9
ГУРАВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА	10
ДӨРӨВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	11
ТАВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЛБАН ХААГЧИД	12–13
ЗУРГАА.	ХУРААНГУЙ	14
ДОЛОО.	ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	15
НАЙМ.	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	16
ЕС.	ДЭЛЖИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	17
АРВАН.	САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	18–19
АРВАН НЭГ.	БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	20–37
АРВАН ХОЁР.	БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	38–40
АРВАН ГУРАВ.	ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	41–43
АРВАН ДӨРӨВ.	ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	44
АРВАН ТАВ.	МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	45–46
АРВАН ЗУРГАА.	ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	47–48
АРВАН ДОЛОО.	СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ	49
АРВАН НАЙМ.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС	50
АРВАН ЕС.	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	51
ХОРЬ.	ТӨСӨВ, САНХҮҮ	52
ХОРИН НЭГ.	ОЛОЛТ, АМЖИЛТ	53
ХОРИН ХОЁР.	2024 ОНЫ ЗОРИЛТ	54

# ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

---

- Зураг 1.** СЗХ–ны бүтэц, зохион байгуулалт
  - Зураг 2.** СЗХ–ны албан хаагчдын мэдээлэл
  - Зураг 3.** Санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын онцлох үзүүлэлтүүд
  - Зураг 4.** Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд
  - Зураг 5.** Санхүүгийн салбарын зохицуулалттай этгээдүүлэлтүүд
  - Зураг 6.** Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл
  - Зураг 7.** Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл
  - Зураг 8.** Зайны хяналт, шалгалтын хүрээнд тайлан, мэдээ /давхардсан тоогоор/
  - Зураг 9.** Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл
  - Зураг 10.** Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл
- 
- Хүснэгт 1.** Дээд газрын тогтоол, шийдвэр
  - Хүснэгт 2.** 2023 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд
  - Хүснэгт 3.** Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтууд
  - Хүснэгт 4.** Банк бус санхүүгийн байгууллагуудын зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>ААНОАТХ</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль
<b>АНДМУТБ</b>	Ази Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллага
<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>ББСБ</b>	Банк бус санхүүгийн байгууллага
<b>ББСБХЧ</b>	Банк бус санхүүгийн байгууллагын хяналтын чиглэл
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард улс
<b>ВХ</b>	Виртуал хөрөнгө
<b>ВХҮҮ</b>	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
<b>ГҮТББ</b>	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ДХЧ</b>	Даатгалын хяналтын чиглэл
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ЗЖДХ</b>	Зээлийн жигнэсэн дундаж хүү
<b>ЗХДЗШШ</b>	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
<b>МДХ</b>	Монголын Даатгалын Холбоо
<b>МЗҮАЭ</b>	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч
<b>МУИС</b>	Монгол Улсын Их Сургууль
<b>МУТА</b>	Мөнгө угаахтай тэмцэх алба
<b>МУТС</b>	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
<b>МУТСТ</b>	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
<b>МҮХАУТ</b>	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
<b>МҮЭ</b>	Мэдээлэх үүрэгтэй этгээд
<b>МХБ</b>	Монголын хөрөнгийн бирж
<b>НДЗАШШ</b>	Нийслэлийн давж заалдах анхан шатны шүүх
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ОТХ</b>	Орлого тооцсон хураамж

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

---

<b>СЗХ</b>	Санхүүгийн зохицуулах хороо
<b>СТОУС</b>	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
<b>СЭЗИС</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ТУЗ</b>	Төлөөлөн удирдах зөвлөл
<b>УБАШ</b>	Улсын байцаагчийн албан шаардлага
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ҮМҮЧЭТХЭАЭ</b>	Үнэт металл, үнэт чулууны эдлэл, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
<b>ҮХЭХЗ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
<b>ҮХЭХ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө
<b>ҮЦЗЗ</b>	Үнэт цаасны зах зээл
<b>ҮЦХЧ</b>	Үнэт цаасны хяналтын чиглэл
<b>ФАТФ</b>	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
<b>ХАА</b>	Хөдөө аж ахуй
<b>ХБҮЦ</b>	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
<b>ХЗХ</b>	Хадгаламж, зээлийн хоршоо
<b>ХЗХХЧ</b>	Хадгаламж, зээлийн хоршооны хяналтын чиглэл
<b>ХК</b>	Хувьцаат компани
<b>ХНХ</b>	Хувь нийлүүлсэн хөрөнгө
<b>ХНХБ</b>	Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц
<b>ХОМК</b>	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
<b>ХОС</b>	Хөрөнгө оруулалтын сан
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХХОАТХ</b>	Хүн амын орлогын албан татварын тухай хууль
<b>ХЭБ</b>	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
<b>API</b>	Application Programming Interface
<b>QR</b>	Quick response code

## МЭНДЧИЛГЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлангаа Танд өргөн барьж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2023 онд санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд голчлон анхаарч ажилласны үр дүнд зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө орчуулагчдын татварын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, гадаадын хөрөнгө оруулагчийг татах чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлж ажиллалаа.

Тухайлбал, УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль амжилттай хэрэгжиж, банкны реформ хийгдэж, банкны системд нөлөө бүхий 5 банк, дотоодын зах зээлээс нийт давхардсан тоогоор 72,365 хөрөнгө оруулагчийн 478.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Хөрөнгө оруулалтын сангийн багц журамд биржээр арилжаалдаг

хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг тусгаснаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж бүрдэж, хөрөнгө оруулагчид шинэ төрлийн бүтээгдэхүүн авах, олон улсын томоохон компаниудын хувьцааны өгөөжийг сангаараа дамжуулан хүртэх боломж бий болж, анхны хамтын биржээр арилжаалагддаг санг бүртгэсэн. 2024 оноос гадаадын хөрөнгө оруулагчийн албан татвар ногдох орлогыг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил тэнцүү, ялгаваргүй байдлаар суутган тооцох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөх хуулийн зохицуулалт бий болж, хөрөнгө оруулагчдыг дэмжсэн татварын эрх зүйн орчныг бүрдүүллээ. Биржийн бус зах зээл бий болж хөрөнгийн зах зээл дээр санхүүжилт татах шинэ гарц нээгдсэнээр компанийн бондын зах зээл хурдастай хөгжиж, компаниудын санхүүжилт татах зах зээлд оролцох оролцоо идэвхжиж, үйл ажиллагаагаа эхэлснээс хойш төгрөгөөр 2,441.4 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг бүртгэж, 1,743.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн доллароор 71 сая ам.долларын өрийн хэрэгсэл бүртгэж 45.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын аж ахуйн нэгж компаниудыг гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity: Hong Kong”, “Shanghai” цуврал арга хэмжээг зохион байгуулах зэрэг

арга хэмжээг цаг тухай бүрд авч хэрэгжүүлсний үр дүнд хөрөнгийн зах зээл маань түүхэн дээд үзүүлэлтдээ хүрч 11.6 их наяд төгрөгт хүрлээ.

Манай улсын экспортын орлогын 90 орчим хувийг эзэлдэг. Уул уурхайн бүтээгдэхүүнийг дундын зуучлалгүй арилжаалах, ил тод болгох, засаглалыг сайжруулахтай холбоотой нийт 13 журам батлан мөрдүүлэн ажиллаж, уул уурхайн биржээр 2023 онд нийт 299 удаагийн 7,541.4 тэрбум төгрөгийн арилжаа явагдлаа.

Даатгалын салбарт ч олон тулгуурт даатгалын салбарыг хөгжүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд иргэдийн орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр, аж ахуйн нэгж, бизнес зээлийн урьдчилгаа төлбөр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид тендер, зээлийн баталгаанд даатгагчийн баталгаа гаргах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Даатгагчийн төлбөрийн чадварын тооцооллыг олон улсын стандарт, жишигт нийцүүлж, даатгагчийн эрсдэлийг бодитой, нарийвчилсан аргаар тооцоолох боломж бүрдэж эрсдэлд суурилсан аргачлал руу шилжлээ.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах, хөгжүүлэх зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, ногоон хөрөнгө оруулалт татах бололцоог бүрдүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажилласан. Ингэснээр ногоон бонд, ногоон зээл, ногоон даатгал зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрсэн төдийгүй ногоон зээлийн

бүтээгдэхүүн болон санхүүгийн жендерийн үзүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэв.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономийг баталснаар Дэлхийд анхдагч улсуудын нэг болсон.

Мөн ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн Ази, Номхон далайн орнуудаас анхны орон, дэлхийд 5 дахь орон боллоо.

Сэндбокс зохицуулалтын хүрээнд технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг амжилттай туршин нэвтрүүлж буй нь бүс нутгийн хэмжээнд сайн жишиг болж байгаа бөгөөд цахим технологид суурилсан хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх шинэ санаа, инновац шийдлийг эрэл хийж санхүү, технологийн салбарт ажиллаж буй залууст зориулан анх удаа текспринт уралдааныг амжилттай зохион байгуулав.

Эдгээр бодлого зохицуулалтын үр дүнд зохицуулалттай санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгө, зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 24.9 хувьтай тэнцэхүй хэмжээнд хүрээд байна.

Ирэх 2024 онд тогтвортой ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих, зохицуулалтын салбарын эх зүйн шинэчлэл хийх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цахим технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг бодлогоор дэмжих, ухаалаг, хүртээмжтэй, тогтвортой зах зээлийг хөгжүүлэхэд гол зорилтоо тавьж ажиллана.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### Хоёрдугаар сар

“Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”, “СЗХ-оос МУТСТ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-г баталлаа

### Дөрөвдүгээр сар

“Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн баталлаа. Хаанбанк үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаа эхлүүлээ

### Зургаадугаар сар

Анхны хамтын биржээр арилжаалагддаг санг бүртгэв  
Хас банк үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаа эхлүүлээ

### Нэгдүгээр сар

Уул уурхайны бүтээгдэхүүний цахим арилжааны туршилт амжилттай явагдаж биржийн үйл ажиллагаа тогтворжлоо

### Гуравдугаар сар

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хэрэгжиж эхэллээ

### Тавдугаар сар

Топ-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх хөтөлбөрийг баталлаа  
Зүүн Европ, төв Азийн бүсийн санаачилгын хурлыг зохион байгууллаа



**Долоодугаар сар**

Монгол Улс ФАТФ-ын техникийн 40 зөвлөмжийг бүрэн ба дийлэнхийг хангасан бүс нутгийн хэмжээнд анхны улс боллоо

**Наймдугаар сар**

“Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ББСБ-уудын чадавхыг бэхжүүллээ

**Есдүгээр сар**

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсын Төв банкны төлөөлөгчид манай улсад айлчлан ногоон санхүүжилтийн орчны талаар туршлага судаллаа

**Аравдугаар сар**

Даатгалын салбар дүрэмд суурилсан уламжлалт аргачлалаас эрсдэлд суурилсан төлбөрийн чадварын аргачлал руу бүрэн шилжлээ

**Арваннэгдүгээр сар**

“Mongolia’s Capital Market Connectivity: Hong Kong”, “MONGOLIAN CAPITAL MARKETS DAY 2023” өдөрлөг боллоо

**Арванхоёрдугаар сар**

Монгол Улсад анх удаа “Санхүүгийн инновац текспринт-2023” уралдаан зохион байгуулагдлаа. Анх удаа ногоон бонд гарлаа

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2006 онд Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталж Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоож өгснөөр үйл ажиллагаагаа 2006 онд эхлүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. Тайлант онд тус Хороо 10 салбарын 3,766 зохицуулалттай этгээд, 2,416 даатгалын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавин ажиллалаа.



### АЛСЫН ХАРАА

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно.



### ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.




### ҮНЭТ ЗҮЙЛС



# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН


Санхүүгийн зохицуулах хороо нь тайлант онд 9 газар, 5 хэлтэс, 6 алба, 158 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулжээ.

Зураг 1. СЗХ-ны бүтэц, зохион байгуулалт





Мөн Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхээр 21 аймагт 63 төлөөлөгч ажиллаж байна.

Зураг 2. СЗХ-ны албан хаагчдын мэдээлэл



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЛБАН ХААГЧИД

### Боловсролын зэрэг




### Зэрэг дэв



### Төрийн албаны тусгай шалгалт

Санхүүгийн зохицуулах хорооны шалгалтын комисс бие даан зохион байгуулж Төрийн албаны зөвлөлийн хурлаар танилцуулдаг болсон.




# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЛБАН ХААГЧИД

## АЛБАН ХААГЧДЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

### Тэрбум мод (2022–2023 он)

- 6,338 модыг Өвөрхангай аймгийн Хархорин суманд тарьсан.
- “Инcheon Мөрөөдлийн төгөл” –д 1,200 орчим мод тарьсан.



### Спорт арга хэмжээ

- “Сар бүр нэг тэмцээн” спорт арга хэмжээг зохион байгуулсан.
- “Эв нэгдэл–Эрүүл мэнд” уриа дор 2023.10.28–ны өдөр Богд–Хан уулын ноён оргил руу авирсан.
- “Хүрд спорт заал” –тай гэрээ байгуулж волейбол, сагсан бөмбөгөөр тогтмол хичээллэх боломж бүрдсэн.

### Албан хаагчдыг хөгжүүлэх

- Долоо хоног бүр “Мэдээллийн цаг” арга хэмжээ зохион байгуулсан.



### Албан хаагчдын эрүүл мэнд

- 96 албан хаагчдыг хоёр удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.
- Албан хаагчдад эрүүл мэндийн үзлэг, оношилгоо 94 удаа мөн 960 удаагийн эмчилгээ үзүүлсэн.
- Нийслэлийн хүүхдийн сэргээн засах төвтэй хамтран албан хаагчдын 0–17 хүртэлх насны 61 хүүхдийг сэргээн засах үзлэг, биеийн болон хэл, сэтгэл заслын үзлэг, уламжлалт эмчийн үзлэг, түүнд тохирсон өдрийн эмчилгээнд хамруулсан.

## ХУРААНГУЙ

Дэлхийн эдийн засаг сүүлийн 30 жилийн хугацаанд хамгийн тааруу өсөлтэй байх 5 жилтэй тулгарч байна гэж Дэлхийн банкнаас танилцуулсан Дэлхийн Эдийн засгийн тоймд дурджээ.

Цар тахлын оргил үед –4.7 байсан Монгол Улсын эдийн засаг 2023 онд 6.8 хувиар өсөж, нийт экспортын орлого цар тахлын өмнөх үеэс хоёр дахин давж, ДНБ 36.7 их наядаас 68.8 их наяд төгрөгт хүрч, нэг хүнд ногдох дотоодын ДНБ анх удаа 5,220 ам.долларт хүрсэн төдийгүй Монгол Улсын төсөв, төлбөрийн тэнцэл анх удаа хамтдаа ашигтай гарсан.

Санхүүгийн зохицуулах хороонд зохицуулалттай санхүүгийн болон санхүүгийн бус салбарын ДНБ-д эзлэх хувь өмнөх оноос 3.8 хувиар өсөж 24.9 хувьтай тэнцэхүйц хэмжээнд хүрэхэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /16.9 хувь/, ББСБ-ын салбарын нийт хөрөнгө /6.8/хувь голлон нөлөөлсөн байна.

**Хөрөнгийн зах зээл:** ХЗЗ дээр 787.2 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдсан ба нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 их наяд 759 тэрбум төгрөг буюу 1.7 дахин өсөж, 11,650.2 тэрбум төгрөгт хүрч хувьцааны хөрвөх чадвар 1.5 хувь боллоо.

ТОП-20 индекс өмнөх онтой харьцуулахад 10.3 хувиар өсөж 41,437.4 нэгжид болсон байна.

Биржийн бус зах зээлд 63 үнэт цаас гаргагчийн 1,065.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 195 транч өрийн хэрэгслийг бүртгэж, 829.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Мөн 59.0 сая долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэж, 33.5 сая долларыг амжилттай татан төвлөрүүлсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 299 удаагийн 7,541.4 тэрбум төгрөгийн арилжаа явагджээ.

ХАА-н гаралтай бараа, таваарын зах зээлийн хувьд 11 төрлийн 968.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 12.8 хувиар буурсан.

**Даатгалын зах зээл:** Тус зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 16.1 хувиар өсөж 551.4 тэрбум төгрөгт, нөөц сан 23.8 хувиар өсөж 268.9 тэрбум төгрөгт тус тус хүрлээ.

Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оноос 30.4 хувиар өсөж 392.0 тэрбум төгрөгт, давхар даатгалын хураамж 41.6 хувиар өсөж 141.6 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын үнэлгээ өмнөх улиралтай харьцуулахад 72.8 хувиар өсөж 252.8 их наяд төгрөг болов. Даатгалын нөхөн төлбөрт өмнөх оноос 28.3 хувиар өсөж 120.9 тэрбум төгрөгийг олгожээ.

**Банк бус санхүүгийн байгууллагын салбар:** ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 4,672.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 32.5 хувиар өслөө. Нийт харилцагчдын тоо давхардсан байдлаар 4.5 сая болсон үүнээс 94.1 хувийг финтекийн харилцагчид эзэлж байна.

ББСБ-уудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оноос 35.0 хувиар өсөж 3,675.9 тэрбум төгрөгт хүрсэн. Зээлийн сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өсөж 3.3 хувьд болжээ.

**Хадгаламж, зээлийн хоршооны салбар:** ХЗХ-нд давхардсан тоогоор 72,521 гишүүддээ санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Хоршоодын нийт хөрөнгө өмнөх оноос 14.5 хувиар өсөж 306.5 тэрбум төгрөг, татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 215.2 тэрбум төгрөг тус тус байна. Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 0.5 хувиар буурч 209.1 тэрбум төгрөгт хүрснээс 3.2 хувийг чанаргүй зээл эзлэв.

**Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар:** ҮХЭХЗ-ын байгууллага нийт 10,343 хэлцлээр, 1,622.9 мянган м.кв талбай, 2,287.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.

Харин 77,430 хэлцлээр 600.0 мянган м.кв талбай, 178.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөдлүүлж, түрээслүүлсэн байна.

**Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбар:** Үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд болон иргэн 3,223.7 кг үнэт металлыг 433.8 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 38.1 хувиар, 3,337.1 кг үнэт металлыг 461.1 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оноос 31.3 хувиар тус тус буурсан байна.

**Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар:** ВХҮҮ-д бүртгэлтэй 921.0 мянган харилцагч байгаагаас 15.2 мянга гаруй харилцагч нь арилжаанд идэвхтэй оролцдог.

Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 84.2 тэрбум төгрөгөөр буурч 241.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн 136.6 тэрбум төгрөг ба өдрийн дундаж арилжаа 150.1 сая төгрөг байна.

**Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн салбар:**

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр 7 хуулийн этгээд бүртгэсэн байна.

**Сэндбоксо зохицуулалтын орчин:** ББСБ-уудын хоорондох репо хэлцлийн үйлчилгээ буюу мөнгөний захын арилжаанд 972 удаагийн репо хэлцэл биелж 179.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Краудфандинг буюу хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь нийт 15 төсөл зуучилж, 64.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж зуучилсан бол P2P зээлийн үйлчилгээгээр 1.7 тэрбум төгрөгийн зээлийг зуучилсан.

Харин технологид суурилсан даатгалын платформуор 315 даатгуулагчдад 15 даатгалын бүтээгдэхүүнийг санал болгожээ.

## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зураг 3. Санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын онцлох үзүүлэлтүүд

Зохицуулалттай санхүүгийн болон санхүүгийн бус салбар ДНБ-д эзлэх хувь

**24.9%**



**787.2 тэрбум ₮**

Үнэт цаасны арилжаа

**41,437.4**

ТОП-20  
индекс



**11,650.2 тэрбум ₮**

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

**829.5 тэрбум ₮ , 33.5 сая \$**

Биржийн бус зах зээлийн арилжаа

**551.4 тэрбум ₮**

Даатгалын хөрөнгө

**120.9 тэрбум ₮**

Даатгалын нөхөн төлбөр



**392.0 тэрбум ₮**

Ердийн болон урт хугацааны даатгалын хураамж



**7** бүтээгдэхүүн Сэндбокс зохицуулалтын орчин

ББСБ-ын зээлдэгчид

**1,600,427**

**3,675.9 тэрбум ₮**

ББСБ-ын Нийт зээлийн үлдэгдэл



**191**

ХЗХ-дын тоо

**29,515**

ХЗХ-дын зээлдэгчид

**7** хуулийн этгээд

МЗҮАЭ

**17,773**

ҮХЭХЗ-ын хэлцлийн тоо

**461.1 тэрбум ₮**

Борлуулсан үнэт металл



**241.9 тэрбум ₮**

Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Дэлхийн эдийн засгийн өсөлт 3.1 хувийн өсөлттэй байсан бол 2024 онд 3.1 хувь, 2025 онд 3.2 хувь болж өсөх төлөвтэй байна. Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт 1.6 хувь байсан бол 2024 онд 1.4 хувь болж буурах төлөвтэй.

Хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн өсөлт 2023 онд 4.1 хувь байсан ба 2024 онд 4.0 хувь болж бага зэрэг буурах төлөвтэй байна.

### Хөрөнгийн зах зээл

Олон улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 106 их наяд ам.долларт хүрчээ.

Нийт зах зээлийн 42.9 хувь буюу 45.5 их наяд ам.долларыг АНУ, 11.2 хувь буюу 11.9 их наяд ам.долларыг БНХАУ, 10.4 хувь буюу 11.0 их наяд ам.долларыг Европын холбооны улсууд, 8.7 хувь буюу 9.2 их наяд ам.долларыг Хөгжиж буй зах зээл, 9.5 хувь буюу 10.1 их наяд ам.долларыг Хөгжингүй зах зээл бүрдүүлж байна.

### Даатгалын зах зээл

Дэлхийн даатгалын хураамжийн хэмжээ 2023 онд 8.9 их наяд ам.доллар байсан бол 2024 онд 9.10 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Нөхөн төлбөр 4.4 их наяд ам.доллар байсан бол 2024 онд 4.6 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй.

### Бичил санхүүгийн зах зээл

Дэлхийн бичил санхүүгийн зах зээлийн хэмжээ 2023 онд 185,69 тэрбум ам.долларт хүрсэн бол 2024 онд 204,01 тэрбум ам.долларт, 2030 он гэхэд тус зах зээлийн өсөлт 10.65 хувиар өсөж 377.1 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

### Виртуал хөрөнгийн зах зээл

Дэлхийн криптовалютын зах зээлийн үнэлгээ 2023 онд 1.73 их наяд ам.долларт хүрсэн нь өмнөх оноос 105 хувиар өссөн. Тус зах зээл дээр биткойны үнэ 155 хувийн өсөлттэй байсан бол Ethereum-ийн үнэ 91 хувиар өссөн.

### Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд:

- MSCI индекс 22.0 хувиар;
- S&P 500 24.0 хувиар;
- NASDAQ 44.6 хувиар;
- Германы DAX 20.3 хувиар;
- Японы Nikkei 28.0 хувиар;
- Францын CAC 12.6 хувиар тус тус өссөн.
- БНХАУ-ын CSI 300 11.4 хувиар буурсан.





## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Зураг 4. Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР
⇒ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ДҮН: 787.2 тэрбум төгрөг	⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 551.4 тэрбум төгрөг	⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 4,672.2 тэрбум төгрөг	⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 306.5 тэрбум төгрөг
⇒ ДАНСНЫ ТОО: 2,555,610	⇒ НИЙТ ХУРААМЖ: 391.9 тэрбум төгрөг	⇒ ХАРИЛЦАГЧИЙН ТОО: 4.5 сая	⇒ ГИШҮҮҮДИЙН ТОО: 72,521
⇒ ХАА-Н ГАРАЛТАЙ БАРААНЫ АРИЛЖААНЫ ДҮН: 968.3 тэрбум төгрөг	⇒ НӨХӨН ТӨЛБӨР: 120.9 тэрбум төгрөг	⇒ ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 1.6 сая	⇒ НИЙТ ЗЭЭЛ: 209.1 тэрбум төгрөг
⇒ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ДҮН: 7,345.2 тэрбум төгрөг	⇒ НӨӨЦ САН: 268.9 тэрбум төгрөг	⇒ НИЙТ ЗЭЭЛ: 3,675.8 тэрбум төгрөг	⇒ НИЙТ ХАДГАЛАМЖ: 215.2 тэрбум төгрөг
	⇒ ГҮНЗГИЙРЭЛТ: 0.60 хувь	⇒ ЗЖДХ: 3.3 хувь	⇒ ЗЖДХ: 2.3 хувь,
	⇒ НЯГТРАЛ: 87,816 төгрөг	⇒ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ: 7.0 хувь	⇒ ХЖДХ: 1.3 хувь
			⇒ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ: 3.2

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зураг 5. Санхүүгийн салбарын зохицуулалттай этгээдүүд



## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН САЛБАР

- ⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 242.8 тэрбум төгрөг
- ⇒ ХУВЬ НИЙЛСЭН ХӨРӨНГӨ: 6.7 тэрбум төгрөг
- ⇒ ХУДАЛДАН БОРЛУУЛСАН: 1,622.9 мянган м.кв талбай, 2,287.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий ҮХЭХ
- ⇒ ХӨЛСЛҮҮЛЭХ, ТҮРЭЭСЛЭХ: 600.0 мянган м.кв талбай, 178.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий ҮХЭХ

## ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

- ⇒ ХУДАЛДАН АВСАН: 433.8 тэрбум төгрөгийн үнэт металл
- ⇒ БОРЛУУЛСАН: 461.1 тэрбум төгрөгийн үнэт металл
- ⇒ ХУДАЛДАН АВСАН: 33.4 тэрбум төгрөгийн үнэт эдлэл
- ⇒ БОРЛУУЛСАН: 20.8 тэрбум төгрөгийн үнэт эдлэл

## ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАР

- ⇒ ХАРИЛЦАГЧИЙН ТОО: 921,022
- ⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 55.7 тэрбум төгрөг
- ⇒ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ: 24.9 тэрбум төгрөг
- ⇒ ДОТООДЫН ВХ-ИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ: 241.9 тэрбум төгрөг
- ⇒ ДОТООДЫН ВХ-ИЙН АРИЛЖААНЫ ДҮН: 136.6 тэрбум төгрөг

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

- ⇒ ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО: 656
- ⇒ НИЙТ ХӨРӨНГӨ: 10,081,582.4 төгрөг
- ⇒ НИЙТ ЗЭЭЛИЙН БАГЦ: 6,029,218.4 төгрөг
- ⇒ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ: 2,742,806.7

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОГТООЛ,  
ШИЙДВЭР

24

Удаагийн  
хуралдаан

476

СЗХ-ны  
хэлэлцсэн  
асуудал

810

СЗХ-ны тогтоол

568

СЗХ-ны даргын  
тушаал

Үнэт цаас	Даатгал	ББСБ	ХЗХ	ҮХЭХҮЭ	Виртуал	Мөнгөн зээл	Бусад
174	39	170	26	366	10	18	7

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг цахим хуудас, [Lisence.frc.mn](http://Lisence.frc.mn) хуудсанд тухай бүр байршуулж, олон нийтэд мэдээлж ажиллалаа.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН:

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 30 хууль, 130 гаруй дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Нийт дүрэм, журам зааврын 66 нь ҮЦЗЗ–д, 25 нь даатгалын салбарт, 19 нь ББСБ–ын салбарт, 6 нь ХЗХ–ны салбарт, 7 нь ҮХЭХЗҮЭЗ–ын салбарт, 6 нь ВХҮҮ–ийн салбарт, 5 нь МЗҮАЭ–ийн салбарт хамаарах актууд байна.

### БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ:

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 бүлэг, 18 дэд зорилтын хүрээнд 207 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж, зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 95.3 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

#### Хүснэгт 1. Дээд газрын тогтоол, шийдвэр

№	Дээд газрын тогтоол, шийдвэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
1	“Алсын хараа 2050” МУ–ын урт хугацааны хөгжлийн бодлого	37
2	Шинэ сэргэлтийн бодлого	3
3	МУ–ын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл	8
4	МУ–ыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	10
5	МУ–ын ЗГ–ын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5
6	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл	8
7	Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	3

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх хүрээнд

Санхүүгийн зохицуулах хорооноос тайлант онд баталсан 21 захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажилласан.

### Хүснэгт 2. 2023 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд


№	Тогтоол, тушаалын дугаар	Дугаар	Хэм хэмжээний актын нэр
1	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 186 дугаар тогтоол	6249	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам
2	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 187 дугаар тогтоол	6250	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам
3	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 189 дүгээр тогтоол	6251	Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 318, А/231 дүгээр хамтарсан тушаал	6253	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам
5	Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2023 оны 144/348 дугаар хамтарсан тушаал	6334	Бизнесийн үнэлгээ хийх журам, Бизнесийн үнэлгээ хийх аргачлал
6	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 383 дугаар тогтоол	6317	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам
7	Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-164/386 дугаар хамтарсан тушаал	6415	Журам батлах тухай
8	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-165/385 дугаар хамтарсан тушаал	6416	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлага
9	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 136 дугаар тогтоол	6222	Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарь батлах
10	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2023 оны 106/298 дугаар хамтарсан тушаал	6258	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал
11	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 дүгээр тогтоол	6426	Итгэлцлийн үйлчилгээний журам
12	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоол	6318	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага
13	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 233 дугаар тогтоол	6302	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
14	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 235 дугаар тогтоол	6303	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
15	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81 дүгээр тогтоол	6184	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам
16	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 82 дугаар тогтоол	6185	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам
17	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 83 дугаар тогтоол	6186	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам
18	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 84 дүгээр тогтоол	6187	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам
19	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоол	6188	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам
20	Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 22 дугаар тогтоол	6134	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам
21	Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 190/71/А-72 дугаар хамтарсан тушаал	6207	Сэндбоксыг зохицуулалтын орчны журам

# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тус хуулийг дагалдан өргөн баригдах Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүллээ.



Улсын Их Хурлаас 2022 онд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Бизнесийн үнэлгээ хийх журам, аргачлалыг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А/144/348 дугаар хамтарсан тушаалаар баталлаа.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нарийвчилсан зохицуулалтыг бий болгох хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд заасан нэр бүхий журмууд болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлагыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалаар тус тус баталсан.

Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны А/167/203 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ын шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлуулсан.

Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны А/167/203 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ын шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлуулсан.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрмийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 383 дугаар тогтоолоор баталсан.



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 399 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчид /брокер/-аас Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд өөрчлөлт оруулж, 2024 оны 7 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд угаасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг “0.02” хувь, самнасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг “0” хувиар тус тус тогтоон түр өөрчилсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын хамтын ХОС-ийн активт тавих шаардлагад Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 464 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж, хамтын ХОС-ийн активт тавих шалгуурыг хөнгөвчлөхтэй холбоотой зохицуулалтыг оруулсан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Банкны реформ

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29–ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Банкны системд нөлөө бүхий банкууд 2023 оны 6 дугаар сарын 30–ны өдрийн дотор олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгон IPO/нээлттэй ХК болох үүргийг хүлээсэн.

Үр дүнд нь системийн 5 банк /Төрийн банк, Голомт банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хасбанк/ амжилттай IPO хийж, нээлттэй ХК болж, нийт 478.54 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн.



### Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд

Тус хуулийг Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23–ны өдөр баталсан бөгөөд 2023 оны 6 дугаар сарын 30–ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс 2023 онд Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, арилжаа, төлбөр тооцоо, үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотойгоор нэр бүхий 4 журмыг баталснаас гадна “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нэр бүхий 7 журмыг мөрдүүлэхийг тус тус зөвшөөрсөн.

### Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нийтэд санал болгон нээлттэй арилжаалагдах үнэт цаас гаргасан тохиолдолд үнэт цаас гаргахтай холбоотой гарсан зардлыг 20 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцох, ХОС-ийн орлогыг татвараас чөлөөлөх, нээлттэй компаниудын ногдол ашгийн татварыг 50 хувиар бууруулах зохицуулалтууд орж, энэ оноос эхлэн дагаж мөрдөгдөж эхлээд байна



Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан ААНОАТХ, ХХОАТХ-уудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Онцлох өөрчлөлтийг дурдвал:

гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхтэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгасан байна;

үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9, 24.1.10–д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд (“ҮЦТХТ” ХХК, Кастодиан) суутган, төсөвт төлж тайлагнана.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Үнэт цаасны бодлогын зөвлөл



Үнэт цаасны бодлогын зөвлөлийн ээлжит хуралдаан тайлант онд 4 удаа хуралджээ.

Хуралдаанаар хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, банкны реформ, уул уурхайн бүтээгдэхүүний

биржийн зохицуулалтын орчин, нүүрсний цахим арилжааны болон үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны шимтгэл, хураамжийн хэмжээг бууруулах, үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт зэрэг цагийн үеийн асуудлуудыг хэлэлцэв.

### ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн хөтөлбөр

ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо МҮХАҮТ-тай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталлаа.



### Онцлох шинэ бүтээгдэхүүн



“Хаан банк” ХК-аас гаргах анхны ногоон бондыг бүргэснээр анхдагч арилжаа хийгдэж 17 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татлаа.



“Хамтын биржээр арилжаалагддаг ХОС” буюу ETF-ийг шинээр бүртгэсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр худалдаж эхлэв.

### Гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын аж ахуйн нэгж компаниудыг Хонконгийн хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх боломжийг бий болгох, хөрөнгийн зах зээлээр дамжуулан Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг таатай болгох улмаар гадаадын хөрөнгө оруулагч нарын Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор “MONGOLIA'S CAPITAL MARKET CONNECTIVITY: HONG KONG” арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд зохион байгууллаа.



МХБ Шанхайн хөрөнгийн биржтэй хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хувьцаа, өрийн хэрэгсэл, ХОС-ийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, дэд бүтцийг өргөжүүлэх, хамтарсан бүтээгдэхүүн гаргах чиглэлд байгуулсан санамж бичгийн хүрээнд “MONGOLIAN CAPITAL MARKETS DAY 2023” арга хэмжээ БНХАУ-ын Шанхай хотноо амжилттай зохион байгууллаа.

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

#### Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга

Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, УИХ-д өргөн мэдүүлэхээр Сангийн яамтай хамтран ажиллалаа.

Багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжрах, даатгалын салбар дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй болох, дотоодын даатгагч нарын чадавх нэмэгдэх, даатгалын үйл ажиллагааны эрх зүйн тодорхойгүй байдал буурах, даатгалын зах зээлийн бүтэц тэнцвэржих зэрэг эерэг нөлөө үзүүлэх юм.

#### Даатгагчийн баталгааны бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчин

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Даатгагч баталгаа гаргахтай холбоотойгоор даатгалын компаниуд нэгдэн хамтын удирдлагын бодлогын зөвлөл байгуулсан. Журам батлагдсанаар даатгалын компаниуд 50 гаруй тэрбум төгрөгийн баталгааг гаргах боломжтой болж нөгөө талаас тендерийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээний зардал буурч, үйлчилгээг илүү амар хялбар байдлаар авах, иргэдийн ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх боломж бүрдсэнээр бусад салбарын үйл ажиллагаанд дэмжлэг болох зэрэг нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

#### Эрсдэлд суурилсан төлбөрийн чадвар

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Энэхүү журам, заавар хэрэгжиж эхэлснээр даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй, нээлттэй, ил тод болохын зэрэгцээ даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан таних, түүнээс сэргийлэх систем нэвтрэх, улмаар салбарын засаглал сайжирч, тогтвортой байдал хангагдах, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын даатгалд итгэх итгэл нэмэгдэх болно.

#### Даатгалын бодлогын зөвлөл

Тайлант хугацаанд Даатгалын бодлогын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж Даатгагчийн баталгаа, Ипотекийн даатгал, олон нийтийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцсэн. Мөн бодлогын зөвлөлөөс олон нийтийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн оролцогчдын оролцоог хангуулах, идэвхжүүлэх зөвлөмж гаргаад байна.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА




### Эрх зүйг орчин сайжруулах хүрээнд

Даатгалын тулгуур зарчим ICP 15 “Хөрөнгө оруулалт” зарчимд тусгагдсан шаардлагуудыг судалж, “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 107/53 тоот хамтарсан тушаалаар батлав.

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчаас жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2022 оны 451/196 тоот,



2023 оны 416/A/187 тоот хамтарсан тушаалыг тус тус баталсан. Жолоочийн даатгалын санд 2022, 2023 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг даатгагч тус бүрийн өмнөх жилийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ОТХ-ийн орлогын дүнгийн 1.6 хувиар тогтоосон.



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 741 дүгээр тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн 1, 3, 4, 11, 13, 19 дүгээр хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт орууллаа. Дээрх нэмэлт, өөрчлөлтөд даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага, давхар даатгагчийн нөөц сангийн бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой зохицуулалтаас гадна даатгалын байгууллагуудын цахим даатгал, жендер болон бусад холбогдох мэдээллийг хүлээн авахтай холбоотой санхүүгийн нэмэлт тайлангийн маягтуудыг шинэчлэн баталлаа.

### Хэлэлцүүлэг, уулзалт, хамтын ажиллагаа

Хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, амьдралын даатгалын компани оролцох боломжийг бүрдүүлэх чиглэлээр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж байна.

МДХ-той хамтран зохион байгуулсан “Даатгалын салбарыг татварын бодлогоор дэмжих нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгээр өнөөгийн татварын хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлууд болон түүнийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэж, санал солилцсон.

“Үндэсний давхар даатгал” ХК-иас хамтран Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүний үр дүн, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцсэн.

Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсэгт ажиллаж байна.

# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР



### Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Банк бус санхүүгийн байгууллагуудын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг Улсын Их Хурлаар дэмжиж ажлын хэсэг ажиллаж байна.

Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн эрхлэх итгэлцлийн үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 дүгээр тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг шинэчлэн баталлаа. Итгэлцлийн үйлчилгээ нь бусдын хөрөнгийг тодорхой хугацаанд удирдах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаа байдгаараа онцлогтой.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны А/226/528 дугаар хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг СТОУС–д нийцүүлэн шинэчлэн баталлаа. Тус журам нь Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн бус хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, санхүүгийн бус өр төлбөр, өөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх, ангилах, үнэлэх, данс бүртгэлд тусгах удирдамжаар хангахын зэрэгцээ СТОУС–9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС–13 Бодит үнэ цэний хэмжилт, СТОУС–7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС–5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС–ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй тусгаж, зохицууллаа.

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх эгнээнд авч үзэн 2023–2025 оныг “Монголд зочлох жил”-ээр зарласантай холбогдуулан төрийн нэгдсэн бодлогыг дэмжин дээд зэрэглэлийн зочид буудал нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлгүйгээр өөрийн үйлчлүүлэгч болох Монгол улсад жуулчлал хийж байгаа нэг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд өдөрт 3 сая төгрөгөөс ихгүй дүнгээр гадаад валют худалдан авах, худалдах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлээ.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 05 А–106/298 тоот хамтарсан тушаалаар “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баталсан. Ингэснээр ББСБ–ууд нь хууль эрх зүйн хувьд зээлийн хүүг хэрхэн тооцох аргачлал нь тодорхой болж, нөгөө талаас зээлдүүлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг танилцуулах үүргийг тусгаж өгсөн.



# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

### Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон дагалдах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг баримт бичгүүдийг эцэслэн Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 1/4922, 1/4923 тоот албан бичгээр тус тус хүргүүлээ.



Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж, Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох болсонтой холбогдуулан нэр бүхий 194 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 68 дугаар тогтоолоор хугацаагүй болгосон.




“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 384 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын хавсралт “Зайнаас эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын төслийн онооны системийг зайнаас нэр бүхий 49 ХЗХ-нд үнэлэв. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023

оны 184 дүгээр тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын төслийн аргачлал, зааварт туршилт хийх ажлын хэсэг” нэр бүхий 8 ХЗХ-нд газар дээр нь туршсан.

### Ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 02 дугаар тушаалаар баталлаа. Үлгэрчилсэн загварт ХЗХ-ны үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн болон гүйцэтгэх захирал, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоолоо. Түүнчлэн түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбоотой шаардлагыг мөн тодорхойлсон юм.



# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР

### Эрхзүйн орчны бүрдүүлэлт

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг мөрдөж эхэлж байгаатай холбогдуулж хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 03 дугаар сарын 13–ны өдрийн хуралдаанаар:

- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам зэрэг таван журмыг баталсан. Эдгээр журмууд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 23–ны өдөр бүртгэгдлээ.

### Олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 137 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг баталлаа.



### Судалгаа, шинжилгээ хийх ажлын хүрээнд



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохтой холбогдуулан «Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох нь» судалгааны ажил гүйцэтгэлээ.

### Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн анхны хуралдаан 10 дугаар сарын 16–ны өдөр болж Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, түүний



хэрэгжилт, холбогдох журмууд болон хуулиар заасан чиг үүрэг, зээлийн хүүгийн судалгаа, зээлийн барьцаа, батлан даалтын гэрээний загварын төсөл, зээлийн хүүгийн хэмжээг тооцох аргачлалын төслийн талаар санал солилцлоо.

### Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх мэргэжилтнүүдэд зориулсан сургалт хэлэлцүүлэг



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл хариуцсан нийслэлийн 9 дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүдэд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын танилцуулга хийж, зөвшөөрлийн цахим системийг хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгууллаа.

Санхүүгийн боловсролын хөгжлийн төвтэй хамтран Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд мэдлэг олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалтад нийт 1,342 иргэн хамрагдан, амжилттай суралцсан 898 иргэнд сертификат олгов.

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

#### Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 235 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан зуучлалын байгууллагуудаас ирүүлэх санхүүгийн тайлан болон зуучлалын мэдээний мастер файлыг боловсруулж, тайлан нэгтгэлийн ФинА системд метадатаг өрж хэрэгжилтийг хангуулсан.



#### Хэлэлцүүлэг, уулзалт, хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал АНУ-д төвтэй Үндэсний реалторуудын холбооны Ази, номхон далайн бүсийн зохицуулагч Марк Китабаяаши болон Вашингтон мужийн реалторуудын холбооны засгийн газар хариуцсан захирал Нэттон Гардон нартай уулзаж олон улсын хөрөнгө оруулагчдад зориулсан ил тод, нээлттэй тодорхой эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцов.



#### Мэргэжлийн “Ёс зүйн дүрэм” болон стандарттай боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооноос ҮХЭХЗ-ын салбарын мэргэжлийн оролцогчдын “Ёс зүйн дүрэм”-ийг боловсрууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 03 тоот тогтоолоор ажил мэргэжлийн үндэсний стандартад үл хөдлөх хөрөнгийн салбарын мэргэжилтэн болох брокер, агентын ажил мэргэжлийг хамруулан батлууллаа.



Монголын ҮХЭХЗ-ын салбарыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, салбарын мэргэжилтнүүд болох брокер, агентуудын хоорондын уялдаа холбоог хангах, туршлага солилцох “Реалторуудын дуу хоолой форум-2023” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР

### Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмаар зуучлалын мэдээний загварыг сайжруулж, статистик тоо мэдээг баяжуулснаар зайны хяналт, шалгалтыг хялбаршуулсан бөгөөд санхүүгийн тайланг улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахаар холбогдох зохицуулалтыг тусгасан болно.



Тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх иргэд ерөнхий мэдээлэл агуулсан QR код бүхий таних тэмдэгтэй боллоо.



### Хэлэлцүүлэг, уулзалт, хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо, Соёлын яам, Монголбанк, Стандарт, хэмжил зүйн газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран хоёр дахь жилдээ үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор “Mongolian jewellery and metal expo” арга хэмжээг “Мишээл экспо” олон улсын худалдааны танхимд 2023 оны 04 дүгээр сарын 13–16-ны өдрүүдэд зохион байгуулсан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН САЛБАР

#### Эрхзүйн орчны бүрдүүлэлт

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 253 дугаар тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын нэмэлт өөрчлөлтийг баталлаа.

Энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу ВХҮҮ нь MNS ISO/IEC 27001-ээс бусад стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

Харин MNS ISO/IEC 27001 мэдээлэл технологийн стандартыг хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх үүрэг хүлээсэн.

#### Хяналт, шалгалтын хүрээнд

Санхүүгийн зохицуулах хороо API системээр дамжуулан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр бодит цагийн горимоор хүлээн авч зайны хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлж ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 59 дүгээр тушаалаар төрийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд бүргэлтэй, бүртгэлгүй ВХ болон ВХҮҮ-ийн холбогдох мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ тайлан дүгнэлт боловсруулсан.

Санхүүгийн зохицуулах хороо “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй ВХҮҮ-ийн технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдал, дотоод хяналт, МУТСТ шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргалаа.

### “Дижитал хөрөнгөөр санхүүгийн хүртээмжийг дэмжих нь” хурал



Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-ны дэргэдэх Санхүүгийн тогтвортой байдлын хүрээлэн (FSI) болон Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс хамтран зохион байгуулсан “Санхүүгийн хүртээмжийг

дижитал хөрөнгөөр дэмжих нь” сэдэвт хурал Швейцар Улсын Базель хотноо боллоо. Хуралд 43 орны 78 байгууллагыг төлөөлөн нийт 150 гаруй албан хаагч оролцож ВХ, стэйблкойн, төв банкны дижитал валютын олон улсын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд үзүүлэх үр нөлөө, үүсэж болзошгүй эрсдэлүүдийн талаар хэлэлцлээ. Энэ үеэр зохион байгуулагч талаас ФАТФ-ын Зөвлөмж 15-ын шаардлагыг хангах нь олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудал хэвээр байна. Харин Монгол Улс энэ чиглэлээр богино хугацаанд цогц арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, бусад орнуудад сайн туршлага болохуйц амжилт үзүүлснийг онцолж, баяр хүргэсэн юм.

### “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн дижитал хөрөнгөөр санхүүгийн хүртээмжийг дэмжих нь» хурал



Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн энэ оны ээлжит “Типологи, хүний нөөцийг

чадавхжуулах семинар” Энэтхэг Улсын Нью-Дели хотноо боллоо. Семинарын “Виртуал хөрөнгө ба виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээ” сэдэвт хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл панелистаар оролцож, Монгол Улс дахь виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүн болоод зохицуулалтын сайн туршлагын талаар илтгэл тавилаа.

### Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-ийн 26 дахь удаагийн чуулга уулзалт



АНДМУТБ-ийн 26 дахь удаагийн чуулга уулзалт Канадын Ванкувер хотноо боллоо. Энэхүү чуулга уулзалтаар Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ФАТФ-ын техникийн 40 зөвлөмжийг “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн, үүнд ВХ-ийн салбартай холбоотойгоор шинэчлэгдсэн “Шинэ технологи” буюу Зөвлөмж 15-ийн хэрэгжилтийг хангалттай үнэлүүлсэн анхны орон болж байгааг АНДМУТБ-ийн удирдлагуудаас онцолж, тусгайлан баяр хүргэлээ.

# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


## СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

### Эрхзүйн орчны бүрдүүлэлт

Технологид суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал орчинд туршиж, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, онцлогт тохирсон хууль эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэх, сайжруулах зорилгоор “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2023 оны 190/71/А-72 тушаалаар шинэчлэн баталсан.

Уг журамтай нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан 290/А-100 тушаалаар “Сэндбоксын зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн батлав. Ингэснээр Сэндбоксын зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбогдох харилцаа тодорхой боллоо.

### Олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд



“Сэндбокс” цэс шинэчлэгдэн сэндбоксын оролцогч байгууллагуудын мэдээлэл, үйл ажиллагааны тойм, сэндбоксын орчны талаарх түгээмэл асуулт, хариулт зэргийг байршуулав.



“Сэндбокс зохицуулалтын орчин гэж юу вэ?”, “Сэндбоксын орчинд хүсэлт хэрхэн гаргах вэ?”, “Сэндбокс зохицуулалт олон улсад”, “Сэндбокс зохицуулалтын орчны хөгжил” сэдэвт зурагт хуудас, Сэндбокс зохицуулалтын орчны гарын

авлага боловсруулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа.

## Сэндбокс зөвлөлийн хуралдаан



Сэндбоксын зөвлөлийн тавдугаар хуралдаан амжилттай боллоо.

Уг хуралдаанаар “Сэндбокс орчны тойм, сэндбоксын албаны үйл ажиллагаа”, “Финтек зохицуулалтын инновац хаб байгуулах суурь судалгаа” болон сэндбоксын орчинд шинээр турших гурван бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг нийт таван асуудал хэлэлцлээ.

Хуралдааны үр дүнд “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ын хөгжүүлж буй биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем болон “Фандиа” ХХК-ийн урамшуулал, хандив, хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд нэг жилийн хугацаатай туршихаар болов.

Ийнхүү биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн систем нэвтэрснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэнэ.

Харин платформд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинэ төрлийн үйлчилгээ бөгөөд сэндбоксын орчинд туршигдаж буй хоёр дахь хамтын санхүүжилтийн үйлчилгээ юм.

## Санхүүгийн инновац ТЕКСПРИНТ-2023



Санхүүгийн зохицуулах хороо, Unread Media-тай хамтран санхүү, технологийн салбарын мэргэжилтнүүд, залууст зориулан анх удаа текспринт уралдааныг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү уралдаан нь санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон сэндбокс зохицуулалтын үйл ажиллагааг таниулах, санхүүгийн зах зээл дэх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цахим технологид суурилсан ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд технологийн дэвшлийг ухаалгаар ашиглах шинэ санаа, инновац шийдлийг тодруулах зорилготой.

## БОДЛОГ, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1

Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд



Нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулж буй хууль, эрх зүй, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг олон нийтэд хүргэх “Про Боно” өдөрлөг, Номын баяр, “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас зохион байгуулсан “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг”, МУИС болон СЭЗДИС-аас зохион байгуулсан “Job Fair” болон Стандарт хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жил ойн хүрээнд зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой холбогдох зөвлөгөө, мэдээллийг иргэд олон нийтэд өгч ажиллалаа.




Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн батлан даалтын сан, Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих сангаас хамтран Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт санхүүгийн боловсрол олгох сургалт зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо” сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөгийг орон нутгуудад бүсчлэн амжилттай зохион байгууллаа. Үүнд: Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор зэрэг нийт найман аймаг.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А/42 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт “Санхүүгийн мэдлэг олгох” агуулгын төсөл боловсруулав.



Санхүүгийн зохицуулах хорооны иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зээлийн шимтгэл, хураамжийн талаар 2D анимэйшн болон Барьцаалан зээлдүүлэх газраас зээл авахдаа юуг анхаарах вэ сэдвээр 1–2 минутын анимэйшн, 2 рийлсийг боловсруулж олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр цацсан.



Мөн Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд хамаарах үйл явдлын нийт 195 мэдээ, ээлжит хуралдааны 21 мэдээ, нийт 43 видео нэвтрүүлэг, ярилцлага, нийтлэлийг олон нийтийн мэдээллийн холбоос [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn), “Ikon.mn”, “Eagle.mn”, “Itoim.mn” “Zarig.mn” болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд тус тус байршууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа, санхүүгийн мэдээ мэдээлэл олгох QR бүхий анонс, стэнд, тараах материалыг нийт 3500 гаруй иргэдэд хүргэж ажиллалаа.



facebook



# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2 Санхүүгийн зах зээлд оролцогчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбарын оролцогчдоо зориулан эрх олгох, мэргэшүүлэх, захиалгат болон бусад сургалтуудыг “Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журам”-ын дагуу зохион байгуулж байна.



Хүснэгт 3. Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтууд

д/д	Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтын төрөл	2023 он	
		Давтамж	Оролцогч
1	Эрх олгох сургалт	48	3,228
2	Мэргэшүүлэх сургалт	19	411
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр	5	291
4	Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэл чиглэлээр	6	244
5	Бусад сургалт	361	8,189
Нийт		493	12,363


Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн нэр бүхий 13 холбоодтой “Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулж 16 төрлийн хөтөлбөрт хамаарах хамтарсан сургалтыг 67 удаа зохион байгуулсан. Эдгээр сургалтад 3,639

оролцогч хамрагдсанаас 2,816 оролцогч Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудад ажиллах болзол шаардлагыг хангасан байна.

## 3 Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд

Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх Удирдлагын академийн багц 4 сургалтад нийт 36 албан хаагч хамрагдан амжилттай суралцаж сертификат олгогдсон байна.

- Үүнд: Тэргүүн түшмэл – 1 албан хаагч
- Эрхэлсэн түшмэл – 3 албан хаагч
- Ахлах түшмэл – 1 албан хаагч
- Мэргэшүүлэх чиглэл – 10 албан хаагч



Нийт албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх ажлын хүрээнд 39 төрлийн сургалтыг дотооддоо зохион байгуулж давхардсан тоогоор 6,162 албан хаагч хамруулав.



Гадаадын 37 төрлийн сургалтад давхардсан тоогоор 81 албан хаагч хамрагдсан.

Ажлын албаны даргын баталсан “Мэдээллийн цаг” хуваарийн дагуу 16 газар, нэгж 16 удаагийн лекцийг албан хаагчдад зориулж зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 20 албан хаагч иргэдээд санхүүгийн боловсрол олгох “Сургагч багш” боллоо.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороонд давхардсан тоогоор 2,496 хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлт цаасан болон цахим хэлбэрээр ирүүлснээс баримт бичгийн бүрдлийг хянаж шаардлага хангаагүй, бүрдэл дутуу 600 хүсэлтэд заавар, зөвлөмж өгч буцаасан, шаардлага хангасан 1,886 хүсэлтийг хүлээн авч, холбогдох бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд шилжүүлсэн.

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэх – 9;
- Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцааг бүртгэх – 1;
- Олон нийтэд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл бүртгэх – 7;
- Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх – 2;
- Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх – 10;
- Хамтын ХОС – тай холбоотой – 2;
- ХОМК тусгай зөвшөөрөл олгох – 1;
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох – 1;
- Оноосон нэр өөрчлөх – 1
- ХБУЦ бүртгэх – 8;
- Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох – 2;
- ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх – 6;
- ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх – 1;
- ҮЦЗЗ-Д брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох – 1;
- Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгох – 1;
- Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах – 2;
- Нэмж гаргасан хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэх – 1;



### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх – 61;
- Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл – 1;
- Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл – 83
- Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгох – 43;
- Эрх бүхий албан тушаалтан томилох зөвшөөрөл хүсэх – 73;
- Даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн 20;
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, ХЭБ бүрэлдэхүүн өөрчлөх зөвшөөрөл – 5;
- Оноосон нэр өөрчлөх – 5;
- Хаягийн өөрчлөлт – 40.



Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг 83 хүнд олгосон.



Даатгалын болон мэргэжлийн оролцогч компанийн салбар нээх 21 тусгай зөвшөөрлийг олгосон.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Зураг 6. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл



Хүснэгт 4. Банк бус санхүүгийн байгууллагуудын зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл

Нийт 529 ББСБ зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаагаас зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг 478 ББСБ зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт 560 зөвшөөрөл, бүртгэл мэдээллийг хянаж шийдвэрлэлээ.

ББСБ-уудын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хүссэн нийт 981 хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэл хөтөлсөн. Цахим хүсэлтийн шийдвэрлэлт 99.0 хувийн биелэлттэй байна.

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох	51
2	Нэгдэх, нийлэх	0
3	Хаалттай өрийн бичиг	0
4	Оноосон нэр өөрчлөх	9
5	Салбар байгуулах	27
6	ХЭБ, ХНХ, ХНХБ	263
7	Хоёрдогч өглөг	0
8	Хаяг байршил өөрчлөлт	69
9	Гүйцэтгэх удирдлага өөрчлөлт	55
10	ТУЗ-ийн бүртгэл	54

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант онд шинэ тусгай зөвшөөрлийг 6, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах 3, сонгуульт гишүүн болон гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт бүртгүүлэх 81, хаяг байршлын өөрчлөлт бүртгүүлэх 6, нийт 96 хүсэлтийг хүлээн авснаас 85 хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэсэн.

Үүнээс 3 ХЗХ-нд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу хүчингүй болгосон. ХЗХ-ны нэгдсэн бүртгэлд бүх ХЗХ-ны дэлгэрэнгүй мэдээллийг оруулж тухай бүр өөрчлөлтийг шинэчлэн бүртгэсэн байна.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:



Санхүүгийн зохицуулах хороонд 2023 онд 30 хуулийн этгээдээс ҮХЭХЗБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэснээр тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗБ-ын тоо 308 боллоо. Энэ нь өмнөх онтой харьцуулахад тус салбарт үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тоо 3-аар өсжээ.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Санхүүгийн зохицуулах хороо нэр бүхий 52 хуулийн этгээд, 428 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна. Энэ нь өмнөх оны харьцуулбал тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 5-аар нэмэгдэж, иргэдийн тоо 37-оор буурсан үзүүлэлт юм.



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тус салбар дээр 12 ВХҮҮ үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээрээс нэр бүхий 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтад заасан 5 үйлчилгээ, нэр бүхий 2 ВХҮҮ нь мөн хуулийн 6.1.1, 6.1.3, 6.1.4 дэх хэсэгт заасан 3 үйлчилгээ үзүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн. Тайланд онд шинээр бүртгүүлэх хүсэлт ирээгүй.

Харин “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-д заасны дагуу ВХҮҮ-ийн санхүүгийн тайланд аудит хийх 6 аудитын компани бүртгүүлсэн байна.





## ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Газар дээрх хяналт, шалгалтын хүрээнд

Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр системийн нөлөө бүхий 5 банк олон нийтийн нээлттэй хувьцаат компани болсноор олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг үнэт цаасны танилцуулгад заасан төсөл хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан эсэхийг шалгах газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж “Төрийн банк” ХК, “Богд банк” ХК–д газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 09 дүгээр тушаалаар баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт, шалгалтын удирдамж”-ийн дагуу нэр бүхий ВХҮҮ–дэд газар дээрх хяналт, шалгалтыг зохион байгуулж баталсан журмын хэрэгжилт, хэрэглэгчийн хөрөнгийн найдвартай хадгалалт, МУТСТ хуулийн хэрэгжилт, виртуал хөрөнгийн арилжаа, шилжүүлэх, хадгалах үйл ажиллагаа, хэрэглэгчийг таньж мэдэх, гүйлгээний хяналт тавих үйл ажиллагаа, системүүдийн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг зохион байгуулж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөн газар дээрх хяналт шалгалтын нэгдсэн тайлан боловсруулсан. Үүний дагуу холбогдох компаниудад шалгалтын тайланг танилцуулж, алдаа дутагдлуудыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

Тайлант хугацаанд 501 зохицуулалттай этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын тайлан дүгнэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар, нийт 49 УБАШ хүргүүлж биелэлтийг тооцсон.

90 хуулийн этгээд, 1 иргэнд 559.5 сая төгрөг /үүнд: ҮЦХЧ 20 этгээдэд 105.5 сая төгрөг, ДХЧ 7 этгээдэд 44.5 сая төгрөг, ББСБХЧ 39 этгээдэд 207.0 сая төгрөг, ХЗХХЧ 1 этгээдэд 1.5 сая төгрөг, МУТА 18 этгээдэд 84.5 сая төгрөг, ХОҮЭХЧ 2 этгээдэд 44.0 сая төгрөг, ҮХЭХЗҮЭ–ийн зохицуулалтын чиглэлээр 4 этгээд 72.5 сая төгрөг/–ийн торгуулийг ногдуулсан бөгөөд төвлөрүүлэлт 86,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу ВХ, ВХҮҮ–дийн дэлгэрэнгүй судалгааг гүйцэтгэж, тайлагнах Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 59 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсгийн хүрээнд Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцон ажилласан. Энэ хүрээнд Монгол Улсад виртуал хөрөнгийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, мөн үйл ажиллагааг зогсоосон нэр бүхий 92 хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас гаргуулан авч, тус бүрийн судалгааг хийж, нэгдсэн тайланг гаргаж Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлснээр эрсдэл бүхий этгээдэд мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлээд байна.



Зураг 7. Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл /салбарын оролцогчдоор/



## ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД:

Тайлант хугацаанд улирал, сар бүрийн тайлан, мэдээ болон “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг 15,404 этгээд ирүүлснээс давхардсан тоогоор 2,382 зохицуулалттай этгээдэд тайлангийн хариу хүргүүлсэн бол 6,046 этгээдэд зохистой харьцаа, зохицуулалт үйлчилгээний хөлс, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах мэдэгдэл, УБАШ-ыг тус тус хүргүүлэн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Ирүүлээгүй 213 этгээдэд анхааруулах мэдэгдэл хүргүүллээ.


Мөн МҮЭ нь гүйлгээг мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа эсэхэд зайны хяналтыг

хэрэгжүүлж, Санхүүгийн мэдээллийн албаны цахим порталд бүртгэлгүй этгээдүүдэд албан бичиг, цахим шуудангаар мэдэгдэл хүргүүлсэн.

Зохицуулалтын байгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авдаг Фина системд тухай бүр сайжруулалтыг хийж, зарим мастер файлд бүтээгдэхүүний төрлийг нэмэх зэргээр холбогдох өөрчлөлтийг тусган ажиллалаа.

Нийт салбарын МҮЭ-дээс 2023 оны эхний хагас жилийн эрсдэлийн үнэлгээний асуулгыг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд авч, эрсдэлийг үнэлсэн. Эрсдэлийн үнэлгээний асуулгын ирц 75 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 8 хувиар өссөн үзүүлэлт байна.

Зураг 8. Зайны хяналт, шалгалтын хүрээнд тайлан, мэдээ /давхардсан тоогоор/



## ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 онд хяналт шалгалт зохицуулалтын чиглэлээр буюу үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ, ҮХЭХЗ, үнэт ҮМҮЧЭТХЭА, мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар нийт 390 асуудал /бүртгэлээс хассан 17, тусгай зөвшөөрлийг сэргээсэн 79, түдгэлзүүлсэн 167, хүчингүй болгосон 122, бусад 5/-ыг хэлэлцүүлэн асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнээс, ҮЦХЧ 36, ДХЧ 4, ББСБХЧ 73, ХЗХХЧ 19, МУТА 34, ҮМҮЧЭТХЭА 224 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Мөн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд төрийн бүх шатны байгууллагуудаас ирүүлсэн санал, мэдээлэл, судалгаа, лавлагаа, хүсэлтийн дагуу зохицуулалттай этгээдүүдийн талаар мэдээ, мэдээллээр хангаж, холбогдох нотлох баримт, санал, дүгнэлтүүдийг хүргүүлж ажиллалаа.

183 ХЗХ-ны бүх гишүүдийн хурлын материалыг хянаж, хариу зөвлөмж хүргүүлж ажилласнаар салбарын хэмжээнд хоршооны засаглал тогтворжиж, хамтын удирдлага сайжрах гишүүдийг бодит мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

45,000 жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, Санхүүгийн зохицуулах хорооноос шүүхэд нэхэмжлэл гарган, 3 шатны шүүх хуралд оролцож, Дээд шүүхээс Санхүүгийн зохицуулах хорооны талд шийдвэр гаргасан. Энэ нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалсан, том хувь нэмэр оруулах шийдвэр болсон.

Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 14 дүгээр тогтоолыг тухайн ҮМҮЧЭТХЭАЭ нь хууль бус гэж үзэн шүүхэд хандсан бөгөөд НДЗХАШШ-ийн 2022 оны 0683 дугаар шийдвэрээр Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг хууль бус гэж үзэх үндэслэлгүй, ЗХДЗШШ-ийн 2022 оны өдрийн 221/МА2022/0749 дүгээр магадлалаар НДЗХАШШ-ийн шийдвэрийг хэвээр үлдээж, Монгол Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 66 дугаар тогтоолоор хяналтын гомдлыг хүлээн авахаас татгалзсан болно.

### УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН ШААРДЛАГА

Санхүүгийн тайлан, мэдээтэй холбоотойгоор газар дээрх хянан шалгалтын 145 УБАШ баталгаажуулж, хариу хүргүүлж ажиллалаа. Газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлтээр 49 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 35 зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэсэн, 7 зөрчлийг хүлээн авахаас татгалзаж, 1 зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлсэн.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн зөрчилтэй холбоотой ирсэн гомдлын дагуу нэр бүхий 1 ХХК-тай холбоотой зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэж, 1 хуулийн этгээдэд 40,000,000 төгрөгийн торгууль, 1 иргэнд 4,000,000 төгрөгийн торгуулийг тус тус ногдуулсан.

Зураг 9. Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороонд тайлант онд нийт 1,138 өргөдөл, гомдол ирүүлсний албан бичгээр буюу цаасаар 719, цахимаар 383, 11–11 төвөөр 36 болно.

Нийт өргөдөл, гомдлын 575 нь даатгал, 250 нь ББСБ, 144 нь үнэт цаас, 18 нь ХЗХ, 151 нь бусад чиглэлээр ирсэн байна.

Даатгалтай холбоотой ирүүлсэн өргөдөл гомдлын

дагуу 207 иргэн, хуулийн этгээдэд 6.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 117 иргэн, хуулийн этгээдэд 3.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулаад байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон итгэмжлэлийн хүрээнд ХЭЗХ-тэй хамтран 3 шатны 7 шүүх хуралдаанд оролцсон байна.

Зураг 10. Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл



# МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор «Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам»-ыг шинэчлэн батлав.


Монголбанкны Ерөнхийлөгчийн А-26 дугаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д ВХҮҮ-тэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг батлуулав.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын зөвлөмж, шаардлагыг хангах, зохицуулалтыг тусган Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 142 дугаар тогтоолоор “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг батлав.



## Явцын тайлан

ФАТФ-ын Зөвлөмж 8 /Ашгийн бус байгууллага/-ийн үнэлгээг ахиулах Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/379 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг



2023 оны 02 дугаар сарын 01-ны өдөр АНДМУТБ-д явцын тайланг хүргүүлсэн.

## “Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 54 дүгээр тогтоолоор уг төлөвлөгөөг баталлаа. Энэхүү төлөвлөгөөний дагуу МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-аас тогтоосон техник хэрэгжилтийн 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг тасралтгүй хэрэгжүүлэх юм.



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцаж байгаа байгууллага
1	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах	2023 он	ФАТФ
2	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
3	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
4	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
5	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
6	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
7	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
8	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
9	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
10	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо
11	Санхүүгийн зохицуулах хорооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023-2030 он	Санхүүгийн зохицуулах хороо

# МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Олон улсын эрхтэй МУТСТ үнэлгээчин

Санхүүгийн зохицуулах хорооноос ФАТФ-ын зөвлөмж, стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг тодорхойлох олон улсын шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд ажиллах эрхтэй хоёр шинжээчтэй боллоо.



### Туршлага хуваалцав

АНДМУТБ-ээс 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Энэтхэг улсын Нью-Дели хотод зохион байгуулсан “Типологи, хүний нөөцийг чадавхжуулах семинар”-т Монгол Улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар дахь зохицуулалтын орчны талаар туршлага хуваалцаж танилцуулга хийв. Уг семинарын үеэр АНДМУТБ-ын зүгээс Монгол Улсыг идэвхтэй оролцож, өөрсдийн сайн туршлагыг бусдад хуваалцсанд албан ёсоор талархал илэрхийлсэн.

## “Vice-co chair” болов

Дэлхийн бодлогын форумар Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Дижитал санхүүгийн үйлчилгээний ажлын хэсгийн 28 дахь удаагийн уулзалтаар зохион байгуулагдсан ээлжит сонгуулиар Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн Дижитал санхүүгийн үйлчилгээ (DFS)-ний ажлын хэсгийн “Vice-co chair” болов.



### Гарын авлагыг боловсрууллаа



“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх болон болзошгүй эрсдэлийг урьдчилан сэргийлэх зорилгоор “Мөнгө угаах гэмт хэрэг, санхүүгийн залилан” гарын авлагыг боловсрууллаа.

## Хяналт шалгалтын хүрээнд

Хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	2022	2023
Газар дээрх шалгалт хийсэн этгээд	60	67	220
УБАШ хүргүүлсэн этгээд	60	135	61
Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн этгээд	–	25	3
Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон этгээд	–	–	15
Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн этгээд	1	1	18

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC) болон Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага (FSS)

Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн үйлчилгээний хороо хооронд 2010 онд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хугацаа дууссан бөгөөд санамж бичгийг шинэчлэхээр ажиллаж байна.



Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA)

Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагтай “Глопак хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн үнэт цаасны хяналтыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.



БНСУ-ын Хадгаламжийн даатгалын корпорац (KDIC)

Бүгд Найрамдах Солонгос Улсын Хадгаламжийн даатгалын корпорацитай байгуулсан харилцан ойлголцох санамж бичгийн хүрээнд олон улсын стандарт, сайн туршлагыг нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд хамтарч ажиллах болно.



Азийн хөгжлийн банк (ADB)

АХБ-ны тусламжтайгаар “Финтекийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх” техникийн туслалцааны төслийг Санхүүгийн зохицуулах хороо ахлан Монголбанк, Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэхээр болов. Төслийн хүрээнд хамтарсан ажлын хэсгийг байгуулж, төслийн зөвлөх багийг сонгон шалгаруулсан бөгөөд зөвлөх баг олон улсын туршлага судлах судалгааны ажлыг хийж гүйцэтгээд байна. Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын санхүүгийн зах зээлийн зохицуулагчид болон санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоо сайжирч, финтекийн орчинд үйл ажиллагаа эрхлэгчдэд таатай боломж бүрдэх юм.



Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн долоон ажлын хэсэгт орж Санхүүгийн зохицуулах хорооны хэрэгжүүлж буй бодлого, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гишүүн байгууллагуудад танилцуулж, туршлага солилцон ажиллаж байна.



Казахстан Улсын Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллага (AFSA)

Казахстан Улсын Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллагатай санхүүгийн мэдээлэл солилцох, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр харилцан техникийн туслалцаа үзүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг цахимаар байгууллаа. Санамж бичиг байгуулснаар Казахстаны тусгай бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй хоёр улсын хөрөнгийн зах зээл дээр ажиллаж буй компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд харилцан туслалцахаас гадна хөрөнгийн зах зээл дээр ажиллахад үйлчлэх хууль эрх зүйн орчныг нийцүүлэх чиглэлээр хамтарч ажиллах боломж бүрдэж байна.



Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудаас тандан судлахаар санал асуулгын судалгааг зохион байгуулсан. Судалгаанд нийт 30 гаруй тусгай зөвшөөрөлтэй байгууллагын 45 мэргэжилтэн хамрагдсан. Төсөл амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд хаалтын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны 5 албан хаагч оролцож, төслийн үр дүнг танилцуулсан.

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Канадын Үнэт цаасны зохицуулагчдын нэгдсэн байгууллага болон Кебек мужийн Санхүүгийн зохицуулагч байгууллагад албан айлчлал хийв.



2023.03.01

2023.03.01

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсын Төв банкны төлөөллийг ногоон санхүүжилтийн чиглэлээр харилцан туршлага судлахаар хүлээн авав.




БНСУ-ын "Хадгаламжийн даатгалын корпорац"-тай хамтын ажиллагаа, техник туслалцааны харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2023.06.27

2023.09.12

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн Дэлхийн бодлогын форумын "Уур амьсгалын өөрчлөлтэй нүүр тулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид" салбар хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан панелистаар оролцов.



Бүгд Найрамдах Казахстан Улсын Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав

2023.11.17



Шанхай хотноо зохион байгуулагдсан "Монголын хөрөнгийн зах зээл" арга хэмжээ зохион байгуулав.

2023.11.23



Шанхай хотноо зохион байгуулагдсан "Монголын хөрөнгийн зах зээл" арга хэмжээ зохион байгуулав.

2023.11.24



Хонконгод "Монголын хөрөнгийн зах зээл" арга хэмжээг зохион байгуулав

2023.11.29



# СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэсэн урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог. Тайлант онд:

- Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэх нь
- Финтек инновацийн хаб байгуулах төслийн суурь судалгаа
- Түүхий эдийн бирж ба үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг бий болгох нь гэх мэт 12 судалгааны ажил гүйцэтгэснээс эмхэтгэн Судалгааны товхимол №4-ийг нийтлүүлээ.



## Санхүүгийн зах зээлийн тойм

Улирал бүр




## “Иргэн таны санхүүгийн мэдлэг” цуврал зурагт хуудас

(Сар бүр)



## “Хүртээмжтэй санхүү” сэтгүүл

Сар бүр




## Санхүүгийн зах зээлийн сарын тойм

(Сар бүр)



## Иргэн таны санхүүгийн мэдлэгт




## Санхүүгийн зах зээлийн 7 хоногийн мэдээ

7 хоног бүр

## Статистик бюллетень

Улирал бүр



Салбарын тойм, сэтгүүл, тоон мэдээлэл, судалгааны ажлыг СЗХ-ны цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn)), цахим шуудан ([rsa@frc.mn](mailto:rsa@frc.mn)) болон 51-261106 утсаар холбогдон авах боломжтой.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС


Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн баталснаар нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээсэн.

“Биелүүл, эсхүл тайлбарла” үнэлгээний аргачлалын

дагуу 2023 онд 124 тусгай зөвшөөрөлтэй этгээдэд кодексийн хэрэгжилтийг давтан үнэлсэн. Уг давтан хянан баталгаажуулалтаар дундаж үнэлгээ 84.9 хувь буюу 26.4 хувиар дээшилсэн дүн гарлаа.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 104 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ оны эцэст 15.2 хувийн ахиц дэвшлийг үзүүлэв.

Кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулсан мэдээлэл



Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 134 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 27 ХК-ийн цахим хуудсанд хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулж Нийтийн мэдээллийн ил тод байдлын

тухай хуульд хэрхэн нийцэж байгаад Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу зайны үнэлгээг гүйцэтгэв. Үүний үр дүнд дараах мэдээллүүд цахим хуудсанд ил тод боллоо.



Компанийн засаглалын хүчтэй тогтолцоо, комплайнсын үр дүнтэй хяналт бүхий байгууллагын соёлыг нэвтрүүлэхэд чиглэсэн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэл” нээлттэй хэлэлцүүлгийг үнэт цаас гаргагч, зохицуулалтай этгээд, мэргэжлийн холбоод, судлаачдын 150 гаруй төлөөллийг

оролцуулан зохион байгуулж, “Комплайнсын эрсдэлээ үнэлэх аргачлал”-ыг оролцогчдод танилцуулан хэлэлцүүлэг өрнүүлснээр зохицуулалттай этгээд бүр комплайнсын эрсдэлээ өөрөө үнэлэх гарын авлагатай болж, эрсдэлийн удирдлагыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлээ.



## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн 27001 стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авсан.
- Зөвлөх үйлчилгээний хүрээнд мэдээллийн технологийн бодлого, журам, баримтжуулсан мэдээллийн хяналтын журам, нууц үг ашиглах журам, гаднын төхөөрөмжийн хяналтын журам, зөрчлийн удирдлагын журам, эрсдэл ба боломжийн үнэлгээний үйл явцын бичиг баримтууд боловсруулсан.
- Стандартын талаарх анхан шатны мэдлэг олгох сургалтыг модуль 5 хүртэлх түвшинд 2023 оны 10 дугаар сарын 17–ны өдрөөс 10 дугаар сарын 27–ны хооронд зохион байгуулсан.

Танилт нэвтрэлтийн нэгдсэн системээр нэвтрэх боломжтой болсон.




Төрийн нэгдсэн зөвшөөрлийн систем рүү API сервисээр мэдээлэл дамжуулах боломжтой болсон.

- Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас шинэчлэгдлээ.
- Зөвшөөрлийн цахим системээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг шууд гаргах боломж бүрдэв.
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, гаднын халдлагад өртөх эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна.



## ТӨСӨВ, САНХҮҮ




### “Хүндэт өргөмжлөл” гардаж авлаа

Санхүүгийн зохицуулах хороо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Хүндэт өргөмжлөл”-ийг гардлаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, дүгнэх аргачлал батлах тухай” тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдүүдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний жилийн эцсийн биелэлтийг дүгнэсэн байна. Энэхүү дүнгээр Санхүүгийн зохицуулах хороо төрийн өмчийн талаарх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтээ 96 хувь буюу “Онц” дүнтэй хангасан тул ийнхүү өргөмжлөл гардсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл энэ үеэр “Санхүүгийн зохицуулах хороо энэ удаагийн дүгнэлтээр төрийн өмчид хандах хандлага, өмч эзэмшилт, хамгаалалт нь сайжирч, хөрөнгийн үр ашиг ч дээшилсэн байна” гэдгийг онцолсон юм.




## 2023 ОНЫ ОЛОЛТ АМЖИЛТ


2023




Банкны реформ,  
төрийн өмчит  
компанийн хувьчлал  
амжилттай хэрэгжлээ




Уул уурхайн  
бүтээгдэхүүн  
биржээр худалдаж  
эхлэлээ




Хувьцаа  
эзэмшигчдийн эрх  
ашгийг хамгаалсан  
шийдвэр  
гаргууллаа



Хөрөнгө оруулагчдыг  
дэмжсэн татварын  
эрх зүйн орчин  
бүрдүүллээ



ФАТФ–ын техникийн  
зөвлөмжийг бүрэн  
дийлэнхийг хангасан  
дэлхийн хэмжээнд  
тав дахь орон боллоо



Анх удаа ногоон  
бонд гарлаа

## 2024 ОНЫ ЗОРИЛТ

